

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/184/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025.02.07</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор Ц.Дорж Утас: 88114307 Цахим хаяг: Dorjts@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗӨСҮТ	Зооноз өвчин судлалын үндэсний төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/48
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Зооноз өвчин судлалын төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын тайлангаар илэрсэн алдаа, зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түшингээс хэтрээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тус байгууллага нь 2024 онд улсын төсвөөс 1,034,559.2 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 1,031,775.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

5020287

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус байгууллага нь түүхт 80 жилийн ойн хүрээн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	146,408,572.5	214,286,029.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,565,421.3	85,421.3
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,565,421.3	85,421.3
3121	Төгрөг	2,565,421.3	85,421.3
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	2,565,421.3	85,421.3
33	АВЛАГА	3,066,975.8	252,720.3
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,066,975.8	252,720.3
35	БАРАА МАТЕРИАЛ	140,776,175.5	213,947,887.8
351	Түүхий эд материал	122,931,649.0	198,844,603.6
35110	Тусгай зориулалттай материал	18,683,667.0	13,980,805.0
35130	Эм боох материал	104,247,982.0	184,863,798.6
354	Хангамжийн материал	17,844,526.5	15,103,284.2
35410	Бичиг хэргийн материал	3,167,950.0	2,223,600.0
35420	Аж ахуйн материал	12,809,214.1	11,962,946.7
35430	Сэлбэг хэрэгсэл	54,000.0	00.0
35440	Түлш, шатах тослох материал	193,062.4	15,237.5
35450	Барилгын засварын материал	913,000.0	901,500.0
35470	Бусад хангамжийн материал	707,300.0	00.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,115,289,280.1	1,210,421,269.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,115,289,280.1	1,210,421,269.8
392	Биет хөрөнгө	919,289,280.1	1,014,421,269.8
39201	Барилга, байгууламж, орон сууц	791,146,839.8	792,146,839.8
39202	Хуримтлагдсан элэгдэл	-94,514,624.9	-111,738,758.5
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,150,000.0	34,150,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-13,966,666.8	-17,646,666.8
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	282,309,169.5	530,027,973.2
39206	Хуримтлагдсан элэгдэл	-95,123,341.9	-224,423,908.2
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,879,323.0	29,279,323.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,027,514.3	-19,490,723.6
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,564,917.8	14,564,917.8
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,128,822.2	-12,447,726.9
393	Биет бус хөрөнгө	196,000,000.0	196,000,000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	196,869,000.0	196,869,000.0
39304	Хуримтлагдсан элэгдэл	-869,000.0	-869,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,261,697,852.6	1,424,707,299.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,619,414.9	407,100.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,619,414.9	407,100.0
413	Өглөг	1,619,414.9	407,100.0



**Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,858.3	00.0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,416,656.6	00.0
4136	Бусад өглөг	189,900.0	407,100.0
41361	Байгууллагад төлөх өглөг	189,900.0	407,100.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,260,078,437.7	1,424,300,199.2
51	Засгийн газрын хувь оролцоо	1,260,078,437.7	1,424,300,199.2
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	427,624,333.4	427,624,333.4
51101	Өмч: - төрийн	427,624,333.4	427,624,333.4
512	Хуримтлагдсан үр дүн	766,001,433.7	930,223,195.2
51210	Өмнөх үеийн үр дүн	766,001,433.7	766,001,433.7
51220	Тайлант үеийн үр дүн	00.0	164,221,761.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,452,670.6	66,452,670.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,261,697,852.6	1,424,707,299.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	791,766,509.1	1,461,264,322.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	160,562,409.1	426,705,122.9
120	Нийтлэг татварын бус орлого	160,562,409.1	426,705,122.9
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	159,799,578.1	237,319,003.8
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	762,831.0	189,386,119.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	631,204,100.0	1,034,559,200.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	631,104,100.0	1,034,559,200.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	631,104,100.0	1,034,559,200.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,000.0	00.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100,000.0	00.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	673,806,466.7	1,297,042,561.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	673,806,466.7	1,297,042,561.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	672,193,455.5	1,294,259,032.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	487,384,919.0	777,937,584.2
210101	Үндсэн цалин	284,338,422.0	448,583,283.8
210102	Нэмэгдэл	141,842,655.2	249,950,476.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,100,000.0	20,735,000.0
210104	Урамшуулал	41,103,841.9	58,668,823.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,926,996.3	103,183,212.9
210201	Тэтгэврийн даатгал	53,769,123.9	66,611,659.2
210202	Тэтгэмжийн даатгал	3,750,969.5	7,836,665.8

**Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,556,180.6	11,230,850.8
210204	Ажилгүйдлийн даатгал	819,556.2	3,383,758.8
210205	Эрүүл мэндийн даатгал	6,031,166.2	14,120,278.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,637,986.8	53,106,252.5
210301	Гэрэл, цахилгаан	4,299,306.6	5,018,753.4
210302	Түлш, халаалт	30,170,040.3	46,477,665.1
210303	Цэвэр, бохир ус	3,168,640.0	1,609,834.0
2104	Хангамж, бараа материалын зардал	18,308,028.0	29,956,541.5
210401	Бичиг хэрэг	2,581,400.0	5,890,850.0
210402	Тээвэр, шатахуун	8,864,327.1	10,013,976.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,260.9	2,820,001.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,112,600.0	1,225,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,949,440.0	10,006,713.1
2105	Нормативт зардал	15,917,703.7	129,406,666.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,917,703.7	117,184,399.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.0	12,222,267.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,175,800.0	24,580,900.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000.0	00.0
210604	Урсгал засвар	3,170,800.0	24,580,900.0
2107	Томилолт, зочны зардал	4,286,000.0	15,930,400.0
210702	Дотоод албан томилолт	4,286,000.0	15,930,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,695,260.0	1,764,720.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.0	81,700.0
210803	Даатгалын үйлчилгээ	00.0	108,900.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,360.0	112,720.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,000.0	77,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	747,900.0	589,400.0
210807	Газрын төлбөр	784,000.0	784,000.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	45,000.0	11,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,860,761.7	158,392,754.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.0	2,405,940.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,860,761.7	155,986,814.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,613,011.1	2,783,529.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	465,000.0	00.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	465,000.0	00.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,148,011.1	2,783,529.4
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,148,011.1	2,783,529.4
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>117,960,042.5</u>	<u>164,221,761.5</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	14,155.3	00.0

**Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	14,155.3	00.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-14,155.3	00.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>117,945,887.2</u>	<u>164,221,761.5</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>631,204,100.0</u>	<u>1,034,559,200.0</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	631,204,100.0	1,034,559,200.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	631,104,100.0	1,034,559,200.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	631,104,100.0	1,034,559,200.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,000.0	0.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100,000.0	0.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>630,684,195.0</u>	<u>1,023,239,400.0</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	630,684,195.0	1,023,239,400.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	629,071,183.9	1,020,455,870.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	494,032,532.8	782,115,700.0
210101	Үндсэн цалин	302,786,732.8	452,646,733.4
210102	Нэмэгдэл	129,691,500.0	250,384,017.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,097,000.0	20,540,775.1
210104	Урамшуулал	41,457,300.0	58,544,173.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,333,500.0	96,203,700.0
210201	Тэтгэврийн даатгал	42,117,800.0	60,528,400.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,955,000.0	7,156,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,359,600.0	12,911,200.0
210204	Ажилгүйдлийн даатгал	991,000.0	1,296,200.0
210205	Эрүүл мэндийн даатгал	9,910,100.0	14,311,900.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,418,540.5	54,352,098.9
210301	Гэрэл, цахилгаан	3,079,860.2	6,264,599.8
210302	Түлш, халаалт	30,170,040.3	46,477,665.1
210303	Цэвэр, бохир ус	3,168,640.0	1,609,834.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,393,350.7	23,763,351.7
210401	Бичиг хэрэг	2,708,400.0	4,928,500.0
210402	Тээвэр, шатахуун	8,798,800.0	9,745,100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,162,150.7	2,916,751.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,112,600.0	1,200,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,611,400.0	4,973,000.0

**Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2105	Нормативт зардал	5,864,200.0	13,838,300.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,208,900.0	12,511,800.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,655,300.0	1,326,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,796,800.0	30,198,800.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,383,000.0	3,759,900.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	893,000.0	829,000.0
210604	Урсгал засвар	3,520,800.0	25,609,900.0
2107	Томилолт, зочны зардал	4,286,000.0	15,930,400.0
210702	Дотоод албан томилолт	4,286,000.0	15,930,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,946,260.0	1,573,520.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.0	81,700.0
210803	Даатгалын үйлчилгээ	0.0	108,900.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,360.0	112,720.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,000.0	77,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	998,900.0	791,300.0
210807	Газрын төлбөр	784,000.0	376,900.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	45,000.0	25,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	2,480,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	2,480,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,613,011.1	2,783,529.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	465,000.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	465,000.0	0.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,148,011.1	2,783,529.4
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,148,011.1	2,783,529.4
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>519905.0</u>	<u>11,319,800.0</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	419,905.0	13,799,800.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	419,905.0	13,799,800.0
2200	Дотоод эх үүсвэрээр	419,905.0	13,799,800.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	419,905.0	13,799,800.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-419,905.0</u>	<u>-13,799,800.0</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	100,000.0	-2,480,000.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,465,421.3	2,565,421.3
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,565,421.3	854,21.3

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,624,333.4	66,483,487.0	566,590,678.7	1,060,698,499.1
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	427,624,333.4	66,483,487.0	566,590,678.7	1,060,698,499.1
C07	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	-28,404,979.7	-28,404,979.7
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,624,333.4	66,452,670.6	766,001,433.7	1,260,078,437.7
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,624,333.4	66,452,670.6	766,001,433.7	1,260,078,437.7
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	427,624,333.4	66,452,670.6	766,001,433.7	1,260,078,437.7
D08	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	164,221,761.5	164,221,761.5
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,624,333.4	66,452,670.6	930,223,195.2	1,424,300,199.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,032,567,800.0	1,031,775,670.6	792,129.4	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,032,567,800.0	1,031,775,670.6	792,129.4	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,032,567,800.0	1,031,775,670.6	792,129.4	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	782,119,700.0	782,115,700.0	4,000.0	100
210101	Үндсэн цалин	450,520,200.0	452,646,733.4	(2,126,533.4)	100.5
210102	Нэмэгдэл	247,390,400.0	250,384,017.6	(2,993,617.6)	101.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,807,900.0	20,540,775.1	4,267,124.9	82.8
210104	Урамшуулал	59,401,200.0	58,544,173.9	857,026.1	98.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,203,700.0	96,203,700.0	-	100
210201	Тэтгэврийн даатгал	60,528,400.0	60,528,400.0	-	100
210202	Тэтгэмжийн даатгал	7,156,000.0	7,156,000.0	-	100

**Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210203	ҮОМШӨ-ний даатгал	12,911,200.0	12,911,200.0	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	1,296,200.0	1,296,200.0	-	100
210205	Эрүүл мэндийн даатгал	14,311,900.0	14,311,900.0	-	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,844,600.0	54,352,098.9	492,501.1	99.1
210301	Гэрэл, цахилгаан	6,120,700.0	6,264,599.8	(143,899.8)	102.4
210302	Түлш, халаалт	46,477,700.0	46,477,665.1	34.9	100
210303	Цэвэр, бохир ус	2,246,200.0	1,609,834.0	636,366.0	71.7
2104	Хангамж, бараа материалын зардал	23,844,700.0	23,839,951.7	4,748.3	100
210401	Бичиг хэрэг	4,317,500.0	4,928,500.0	(611,000.0)	114.2
210402	Тээвэр, шатахуун	9,810,000.0	9,745,100.0	64,900.0	99.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,027,100.0	2,916,751.7	110,348.3	96.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.0	1,200,000.0	(100,000.0)	109.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,590,100.0	5,049,600.0	540,500.0	90.3
2105	Нормативт зардал	13,838,300.0	13,838,300.0	-	100
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,214,500.0	12,511,800.0	(297,300.0)	102.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,623,800.0	1,326,500.0	297,300.0	81.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,027,500.0	43,922,000.0	105,500.0	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,483,100.0	16,483,100.0	-	100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	916,600.0	829,000.0	87,600.0	90.4
210604	Урсгал засвар	26,627,800.0	26,609,900.0	17,900.0	99.9
2107	Томилолт, зочны зардал	16,020,000.0	15,930,400.0	89,600.0	99.4
210702	Дотоод албан томилолт	16,020,000.0	15,930,400.0	89,600.0	99.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,669,300.0	1,573,520.0	95,780.0	94.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	81,700.0	81,700.0	-	100
210803	Даатгалын үйлчилгээ	134,200.0	108,900.0	25,300.0	81.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,100.0	112,720.0	1,380.0	98.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.0	77,000.0	22,000.0	77.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	791,300.0	791,300.0	-	100
210807	Газрын төлбөр	376,900.0	376,900.0	-	100
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	72,100.0	25,000.0	47,100.0	34.7

**Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,991,400.0	-	1,991,400.0	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,034,559,200.0	1,034,559,200.0	-	100
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,034,559,200.0	1,034,559,200.0	-	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,034,559,200.0	1,034,559,200.0	-	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28	25	3	89.3
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	28	25	3	89.3

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,565,421.3	2,480,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,565,421.3	2,480,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,565,421.3	2,480,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,565,421.3	2,480,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,565,421.3	2,480,000.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь 2024 оныг "Чанар, дотоод хяналтыг сайжруулах" болгон зарлаж, байгууллагын түүхт 80 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлжээ. Байгууллагын удирдлагын баг 5 удаа хуралдаж, нийгмийн баталгааг хангах чиглэлээр, үндсэн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 22 асуудлыг шийдвэрлэн ажилласан байна.

Зоонозын халдварт өвчнийг илрүүлэх энгийн ПСР шинжилгээний арга аргачлалыг нэвтрүүлж, 210 ширхэг хачгийн 46 ширхэг нь хачигт риккетсиоз өвчний халдваржилтын хувь 21,9%, тарваган тахал өвчний байгалийн голомтын хайгуул, тандалт шинжилгээнд эерэг материал болон өсгөвөр байхгүй болохыг тогтоосон.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоол (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам)

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 83 дугаар тогтоол (Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам)

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 132 тоот зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зооноз өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Эрүүл мэндийн яамны 2010 оны 04 дүгээр сарын 16-ний өдрийн 138 дүгээр тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3-т Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 163,009.5 мянган төгрөг буюу 12.9 хувиар өссөн байна.

**Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	/мянган төгрөгөөр/					
	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	
	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	146,408.3	11.6	214,286.0	15.0	67,877.7	41.6
МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,565.4	1.8	85.4	0.0	(2,480.0)	(3.7)
АВЛАГА	3,066.9	2.1	252.7	0.1	(2,814.2)	(4.1)
УРЬДЧИЛГАА	-	-	-	-	-	-
БАРАА МАТЕРИАЛ	140,776.2	96.1	213,947.9	99.8	73,171.7	107.8
НӨӨЦИЙН БАРАА	-	-	-	-	-	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,115,289.3	88.4	1,210,421.3	85.0	95,132.0	58.4
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,115,289.3	88.4	1,210,421.3	85.0	95,132.0	58.4
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	(230,629.9)	(18.3)	(386,616.8)	(27.1)	(155,986.9)	(95.7)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,261,697.8	100.0	1,424,707.3	100.0	163,009.5	100.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,619.4	0.1	407.1	0.1	(1,212.3)	(0.7)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,260,078.4	99.9	1,424,300.2	99.9	164,221.8	100.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,261,697.8	100.0	1,424,707.3	100.0	163,009.5	100.7

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 85.4 мянган төгрөг байгаа нь ахмадын сангийн үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 252.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 2,814.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 213,947.7 мянган төгрөг болж өмнөх оноос 73,171.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн худалдан авалтаар Тусгай зориулалттай материалд 2,413.9 мянган төгрөг, Эм боох материалд 15,660.8 мянган төгрөг, бичиг хэргийн материалд 4,966.5 мянган төгрөг, Аж ахуйн материалд 5,968.5 мянган төгрөг, Сэлбэг хэрэгсэлд 2,221.2 мянган төгрөг, Түлш, шатах тослох материалд 9,745.1 мянган төгрөг, Барилга засварын материалд 19,926.2 мянган төгрөг, Хүнсний материалд 172.5 мянган төгрөгийн бараа материал, үнэ төлбөргүйгээр Түлш, шатах тослох материалд 91.0 мянган төгрөг, ЗӨСҮТ -өөс 16 нэр төрлийн 34.267 ширхэг 173,591.9 мянган төгрөгийн, ЭМЯ -наас 5 ширхэг 1,117.1 мянган төгрөгийн, Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 11 нэр төрлийн 16 ширхэг 7,196.0 мянган төгрөгийн, БОАЖГ -аас 2 нэр төрлийн 11 ширхэг 990.0 мянган төгрөгийн, Анти Ген ХХК -аас 6 нэр төрлийн 18 ширхэг 6,400.0 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодисыг орлогод авч. Эм боох материал, тусгай зориулалтын материал, түлш шатах, тослох материал, бичиг хэргийн материал, сэлбэг хэрэгсэл, барилга засварын материал данснаас 88,674.0 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн, байгууллагын даргын 2024 оны 7 дугаар сарын 08 -ний өдрийн А/29, 2024 оны 12 дугаар сарын 31 -ний өдрийн А/41 дугаар тушаалуудаар Тусгай зориулалттай материал данснаас 29 нэр төрлийн 12,222.3 мянган төгрөг, Эм боох материал данснаас 23 нэр төрлийн 70,582.8 мянган төгрөг, Бичиг хэргийн материал материал данснаас 27 нэр төрлийн 1,029.1 мянган төгрөг, Аж ахуйн материал данснаас 68 нэр төрлийн 3,659.5 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл данснаас 2 нэр төрлийн 54.0 мянган төгрөг, Барилга засварын материал данснаас 5

нэр төрлийн 360.0 мянган төгрөг, Бусад хангамж материал данснаас 4 нэр төрлийн 707.3 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө акталж устгасан нь бараа материалын данс өсөхөд голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,210,421.3 мянган төгрөг болж 95,132.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 1,000.0 мянган төгрөгөөр албан конторын гадна хаалгыг шинэчлэн сольж капиталжуулсан байна

Молекулын лабораторийн 5 нэр төрлийн 6 ширхэг 12,799.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсан.

Үнэ төлбөргүйгээр Эрүүл мэнд сайдын 2024 оны 05 дугаар сарын 21 -ний өдрийн А/231 дугаар тушаалаар 3 ширхэг 7,389.0 мянган төгрөгийн суурин компьютер, аймгийн Эрүүл мэндийн газраас 21 нэр төрлийн 23 ширхэг 227,530.0 мянган төгрөгийн Молекулын лабораторийн тоног төхөөрөмж, байгууллагын түүхт 80 жилийн ойн хүрээнд хамтын ажиллагааны хүрээнд Би Ай Эм Би ХХК -аас 2,400.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил өгсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,424,300.2 мянган төгрөг, тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 164,221.8 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Өр төлбөр нь 407.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 1,212.3 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,061,868.1 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 164,508.9 мянган төгрөгөөр бууруулж 897,359.2 мянган төгрөгөөр баталсан байна. 2024 оны 4 дүгээр сард төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор 137,200.0 мянган төгрөгийн санхүүжилт орж ирсэнтэй холбоотой.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1,034,559.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,033,767.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,033,767.1 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь эд хогшил худалдан авах 792.1 мянган төгрөг зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,032,567.8	1,031,775.7	792.1	99.9
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,991.4	1,991.4	-	100
3	Дүн	1,034,559.2	1,33,767.1	792.1	99,9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Байгууллагын даргын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/42 дугаар тушаалаар 2,480.0 мянган төгрөгийн ахмадын сангаас байгууллагын ахмадууд хүндэтгэл үзүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд принтер 2 ширхэг нэг бүрийн үнэ 549.9 мянган төгрөг нийт 1,099.8 мянган төгрөг, 4 нэр төрлийн 11,700.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, барилга байгууламж дансанд албан конторын барилгын гадна хаалгыг 1,000.0 мянган төгрөгөөр албан конторын гадна хаалгыг шинэчлэн сольж капиталжуулсан. Оны эхэнд НИК ХХК -тай тээвэр шатахууны зардал дээр 9,810.0 мянган төгрөгийн шууд гэрээ хийсэн. Тус байгууллага нь түлш, халаалт 46,477.7 мянган төгрөг, цэвэр бохир усны төлбөр 2,246.2 мянган төгрөгийн гэрээг Чандмань Баянхонгор ХК, Гэрэл цахилгаан зардал 6,120.7 мянган төгрөгийн гэрээг Баянхонгор эрчим хүч ЦТХХК хийсэн байна.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд эм боох материалд 15,660.8 мянган төгрөг, барилга засварын материалд 19,926.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Дорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2024 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Зоонозын өвчин судлалын төвийн дарга Б.Алтанчимэг, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч П.Мөнх-Эрдэнэ, 2024 оны 1 дүгээр сараас 2 дугаар сар, нягтлан бодогч Э.Насанжаргал 2024 оны 3 дугаар сарын 01 -нээс 9 дүгээр сарын 30 -нийг, нягтлан бодогч Т.Одонтуяа 2024 оны 10 дугаар сарын 1 -нээс хойш зурсан байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 1,034,559.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,345.6 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 6,724.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5.1 заасны дагуу хамаарах асуудал байхгүй бөгөөд 792.1 мянган төгрөгийн хэмнэлт гарч улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-д заасан орлогын 1,031,649.2 мянган төгрөгийн 13 гүйлгээг хугацаанд нь 3,045.5 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын 19,809.5 мянган төгрөгийн 3 гүйлгээг хуулийн хугацаанд мэдээлсэн, 6.4.8 “Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл”-д заасан 116,493.3 мянган төгрөгийн 8 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-д заасан 3,045.5 мянган төгрөгийн 1 мэдээлэл, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-ийн 116,493.3 мянган төгрөгийн 8 шийдвэрийг мэдээлэх албан шаардлага өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Цэвээнсүрэн гүйцэтгэж аудитаар 3,280.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 1,619.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 4,648.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2024 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн 55 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	3,280.0	2	3,280.0	100%
Албан шаардлага	1	1,619.4	1	1,619.4	100%
Зөвлөмж	1	4,648.9	1	4,648.9	100%
Нийт дүн	4	9,548.3	4	9,548.3	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн төслийн үндэслэлтэй хийх, нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татварын авлага, өглөг үүсгэхгүй байх. Нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж баталгаажуулах. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Зоонозын судлалыг үндэсний төвөөс 2022 онд олгосон 10,000 ширхэг 95,640.0 мянган төгрөгийн нүдний шил нь ашиглагдах боломжгүй болж Байгууллагын даргын 2024 оны А/41 дугаар тушаалаар 7,087 ширхэг 67,780.1 мянган төгрөгийн нүдний шилийг акталж устгасан. Мөн 2024 оны 6 дугаар сард 4 удаагийн олголтоор 4.555 ширхэг 142,253.1 мянган төгрөгийн нэг удаагийн комбинезон хувцас олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 т “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Зоонозын судлалын үндэсний төв болон Эрүүл мэндийн яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар анхаарч үзэх хэрэгтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,108.5 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн улсын төсвийн санхүүжилт 1,991.4 мянган төгрөгийг санхүүжилтийн орлогоор бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аймгийн Эрүүл мэндийн газраас өгсөн 5 нэр төрлийн 1,117.1 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг Эм боох материал дансанд орлогоор бүртгээгүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 121,573.8 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс 120,157.8 мянган төгрөгийн 3 албан шаардлага өгсөн болно.

5.1 Албан шаардлага

5.1.1 Анхан шатны баримтын шаардлага хангахгүй баримтаар албан томилолт бодож томилолтын зардлаас 1,416.0 мянган төгрөгийг олгосон байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. 14 дүгээр зүйлийн 14.3.1-т анхан шатны баримт бүрдүүлэх. 20 дугаар зүйлийн 20.2.3-т холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах; гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаагүй баримтаар төлбөр тооцоо хийхгүй байх албан шаардлага өгч байна.

5.1.2 2024 оны 1-12 сарууд 4 албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээг буруу мэдээлж 618.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зөрүү үүссэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө нь хянан баталгаажуулах”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25 “ны өдрийн А/199 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам” -ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нэр бүхий 4 албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээг нөхөн мэдээлэх албан шаардлага өгч байна.

5.1.3 Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-д заасан орлогын 1,031,649.2 мянган төгрөгийн 13 гүйлгээг хугацаанд нь 3,045.5 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын 19,809.5 мянган төгрөгийн 3 гүйлгээг хуулийн хугацаанд мэдээлсэн, 6.4.8 “Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл”-д заасан 116,493.3 мянган төгрөгийн 8 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл” заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-д заасан 3,045.5 мянган төгрөгийн 1 мэдээлэл, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-ийн 116,493.3 мянган төгрөгийн 8 шийдвэрийг мэдээлэх албан шаардлага өгч байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн улсын төсвийн санхүүжилтийг орлогоор бүртгээгүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх "үнэн зөв байх" заалтыг зөрчсөн	1	1,991.4	1	1,991.4			1	1,991.4		
Эрүүл мэндийн газраас олгосон эм эмнэлгийн хэрэгсэл эргэлтийн хөрөнгөнд бүртгэл тусгаагүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх "үнэн зөв байх" заалтыг зөрчсөн	1	1,117.1	1	1,117.1			1	1,117.1		
Дүн	2	3,108.5	2	3,108.5			2	3,108.5		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно". Анхан шатны баримтын шаардлага хангахгүй, баримтаар дотоод албан томилолтын зардлаас 1,416.0 мянган төгрөгийг олгосон байна.	1	1,416.0			1	1,416.0		
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25 "ны өдрийн А/199 дугаар тушаалаар батлагдсан "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам" Нэр бүхий 4 албан хаагчдын нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээг нөхөн мэдээлэх	1	618.9			1	618.9		
Дүн	2	2,034.9			2	2,034.9		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-д заасан 3,045.5 мянган төгрөгийн 1 мэдээлэл, 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"-ийн 116,493.3 мянган төгрөгийн 8 шийдвэрийг мэдээлэх.	1	119,538.8			1	119,538.8		
Дүн	1	119,538.8			1	119,538.8		

-----oOo-----